

ГАДААД БОЛОВСРОЛЫН ТҮНШЛЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА

Гадаад боловсролын түншлэлийг өргөжүүлэн ажиллаж байна

2024 оны 06-р сард БНХАУ-ын Өвөрмонголын Шилийн гол аймгийн ажил мэргэжлийн сургуульд багш туршлага судалж, сургалтад хамрагдаад ирлээ

2024 оны 10-р сард ОХУ-ын Эрхүү хотын 5 их дээд сургуулиудад багш, ажилтан туршлага судалж, сургалтад хамрагдан хамтын ажиллагааг өргөжүүлэх протокол үйлдлээ

2024 оны 11 сард БНСУ-д багш, ажилтан туршлага судалж, хамтын ажиллагааны гэрээ байгуулж төгсөгчдийн уулзалт хийлээ



БНСУ-д албан томилолтоор ажиллав

ҮҮПК-ийн Захирал Д.Буяндэлгэр, Сургалтын менежер Б.Мядагдам, сургалтын арга зүйч Ц.Хулан Хоол үйлдвэрлэл мэргэжлийн багш С.Цэнд-Аюуш, Дизайны багш Н.Саруул-Оргил Солонгос хэлний багш С.Ариунаа нар БНСУ-д албан томилолтоор ажиллав

БНСУ-ын их дээд сургуулиудтай боловсролын түншлэлийн хүрээнд +хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж багш нарыг нарийн мэргэшүүлэх, шинэ технологи, сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, багш оюутан солилцоо, сургалтын орчин, үйлдвэр аж ахуйн нэгжтэй танилцах туршлага судлах зэрэг олон талт ажлуудыг хийлээ

Бид олон улсын хөтөлбөр хэрэгжүүлж буй мэргэжлүүдийн тоог нэмж техник, технологийн шинэчлэлийг сургалтын хөтөлбөрт тусгаж байна

1+1 хөтөлбөрийг Агаарын хөлгийн үйлчилгээний ажилтан мэргэжлийн нийт ээлжийн суралцагчид амжилттай хамрагдан шатлан суралцаж анхны төгсөгчид Монгол улсдаа ирж өөрсдийн эзэмшсэн мэргэжлээр ажиллаж байна

1+1 хөтөлбөрийг өргөжүүлэн “Зочид буудлын үйлчилгээ” Гоо сайхны үйлчилгээ” хөтөлбөрүүдээр өргөжүүлэн элсэлт авч суралцуулж байна

2025-2026 оны хичээлийн жилээс Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ”-ний хөтөлбөрийг +, + хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ханган, хамтран ажиллах гэрээ байгууллаа

Мэдээллийн технологийн олон улсын хөтөлбөрийг өргөжүүлэн Пийрсон хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдыг төгсөхөд БНСУ-ын их дээд сургуулиудад шатлан суралцуулах боломжийг судлан хэрэгжүүлэхээр боллоо

Томилолтын хугацаанд БНСУ-ын их сургуулиудын зохион байгуулсан соёлын арга хэмжээнүүдэд оролцлоо



МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Гоо сайхны үйлчилгээ мэргэжлийн ажил, олгогчдын уулзалт зохион байгуулагдлаа

Гоо сайхны үйлчилгээ мэргэжлийн ажил, олгогчдын уулзалт зохион байгуулагдлаа

Гоо сайхны үйлчилгээ мэргэжлийн Ажил олгогчдын уулзалт амжилттай болж өндөрлөлөө

Тус уулзалтанд сургуулийн удирдлага, мэргэжлийн багш нар ажил олгогчид болон мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцлоо Үүнд:

Монголын мэргэжлийн Үсчин Гоо Засалчдын Нэгдсэн

Холбооны тэргүүн Ц.Цогзолмаа,

Монголын Ваксчдын холбооны тэргүүн “Салон мастер

артист” Олон улсын шүүгч Э.Урангоо

Orhkon beauty salon захирал “Салон мастер артист”

Олон улсын шүүгч Б.Орхонлхам

Чимэг” салоны захирал “Салон мастер артист” Олон улсын шүүгч

Thuya salon” салоны захирал Г.Энхмаа

Trippy nail lash room salon захирал Г.Хүсэлсайхан болон

бусад хамтарч ажилладаг аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл оролцлоо

Тус уулзалтын хүрээнд:

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн сургалтын үйл ажиллагаа, сургалт явуулж буй мэргэжлүүдийн танилцуулга

Ажил олгогч төрийн болон хувийн байгууллагуудын танилцуулга

Мэргэжлийн онцлог, чиг хандлага, зах зээлийн эрэлт хэрэгцээ

Суралцагчдын мэргэжил сонгох, мэргэжилдээ үнэнч байх, төлөвшил хандлага

Мэргэжлийн боловсролын байгууллага ажил олгогчдын харилцаа, нийгмийн түншлэл, хамтын ажиллагааны талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа

Энэхүү уулзалтын ач холбогдол нь мэргэжлийн хөтөлбөрүүдийн агуулгын шинэчлэлд ажил олгогчдын санал хүсэлт, ажлын байрны шаардлага зах зээлийн эрэлт хэрэгцээ, шинэ техник технологиудыг тусгах, хамтран ажиллах гэрээ хийх зэрэг олон талын ач холбогдолтой юм



УР ЧАДВАРЫН УРАЛДААН АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

УУПК - ийн ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ТЭНХИМИЙН БАГШ НАРЫН УР ЧАДВАРЫН УРАЛДААН АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

Багшийн хөгжлийг дэмжих, шилдэг арга зүй, тэргүүн туршлагыг илрүүлж түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хичээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дараагийн шатанд оролцох багшаа тодруулах зорилготойгоор тэнхимийн багш нарын ур чадварын уралдааныг зохион байгууллаа.

Шүүгчээр арга зүйч И. Оюунчимэг, ХУТ -ийн эрхлэгч Г. Долгоржав нар ажиллалаа.



Багш нарын заах арга зүйн ур чадварын уралдааныг амжилттай зохион байгууллаа

УУПК-ийн сургалтын албанаас 2024-2025 оны хичээлийн жилийн Багш нарын заах арга зүйн ур чадварын уралдааныг амжилттай зохион байгууллаа

Шүүгчдээр МУБИС-ийн Боловсрол судлалын доктор Д.Базарваань, болон МБС-ын заах арга зүйн зөвлөх С.Пүрэвмаа, багшийн хөгжил хариуцсан ажилтан Ц.Мөнхнаран нар ажилласан бөгөөд уралдаанд тэнхим тус бүрийн төлөөлөл нийт багш нар оролцсоноос:

1-р байранд Э.Оюунчимэг багш “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн таних тэмдэглэгээг таниулах” хичээлээр (Техник, технологийн тэнхим)

2-р байранд Д.Болормаа багш “Шарсан махан хоол бэлтгэх” хичээлээр (Үйлдвэрлэлийн тэнхим)

3-р байранд Н.Ууганбаяр багш “Зохиолчийн ашигласан баримт, жишээнд дүгнэлт гаргах” хичээлээр (Хүмүүнлэгийн ухааны тэнхим) тус тус эхний байрыг эзэллээ



МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ



УР ЧАДВАРЫН УРАЛДААН АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

ҮҮПК - ийн БАЙГАЛИЙН УХААНЫ ТЭНХИМИЙН БАГШ НАРЫН
УР ЧАДВАРЫН УРАЛДААН АМЖИЛТТАЙ БОЛЖ
ӨНДӨРЛӨЛӨӨ

Багшийн хөгжлийг дэмжих, шилдэг арга зүй, тэргүүн туршлагыг илрүүлж түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хичээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дараагийн шатанд оролцох багшаа тодруулах зорилготойгоор тэнхимийн багш нарын ур чадварын уралдааныг зохион байгуулж Газарзүйн багш Э.Наранжаргал түрүүлж дараагийн шатны сургуулийн ур чадварын уралдаанд оролцохоор боллоо Э.Наранжаргал багшдаа амжилт хүсье



МСҮТ, ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖУУДЫН ОЮУТАН СУРАЛЦАГЧДЫН ДУНД ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭН

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн нэрэмжит МСҮТ, ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖУУДЫН ОЮУТАН СУРАЛЦАГЧДЫН ДУНД ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭН сургуулийн баг тамирчид оролцож шилдэгүүдээ шалгарууллаа.Үүнд:

Эрэгтэй баг

- Тэргүүн байр ҮҮПК

- Дэд байр ҮҮПК

- Гутгаар байр МСПК

Эмэгтэй баг

- Тэргүүн байр ҮҮПК

- Дэд байр БПК

- Гутгаар байр ҮҮПК

Шилдэг дасгалжуулагчаар ҮҮПК-ийн багш Спортын мастер Ч. Ариунтуяа

Шилдэг довтлогч ҮҮПК Н.Улам-Оргил

ҮҮПК Х.Номинзаяа

Шилдэг холбогч МСПК М.Энхсаран

ҮҮПК Б.Буянхишиг

Тэгш тоглогч ҮҮПК М.Эрдэнтуул

БПК С.Энхманлай

Тоглолтын нийлбэр дүнгээр ҮҮПК-ийн баг тамирчид

Шилдэгээр шалгарч Цом өргөмжлөл гардаж авлаа



УР ЧАДВАРЫН УРАЛДААН АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

Соёлын бүтээлч сар 2024 Чингис хаан Үндэсний музейн “Хүннү өв” сэдэвчилсэн тайлбарт аялалд Үйлдвэрлэл Урлалын политехник коллежийн “Мэргэжлийн боловсрол сургалтын” 1-р ангийн нийт гаруй суралцагчид багшийг Чингис хаан Үндэсний музейн боловсролын хөтөлбөрийн хүрээнд ХУТ-н Түүх, нийгэм судлалын хөтөлбөрийн баг зохион байгуулан багш суралцагчдыг хамрууллаа



МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

АХИЦ ДЭВШЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙГДЛЭЭ

Оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлийн хөтөлбөрийн ахиц дэвшлийн үнэлгээ хийгдэж шинжээчээр Д.Адилбиш, С.Даваацэрэн нар ажиллаа



ДЭЭЛТЭЙ МОНГОЛ” ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

1924 оны 11 дүгээр сарын 26-ний өдөр Монгол улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Хаант засгаас Бүгд найрамдах засаглалд шилжиж, хамжлагат ёсыг халан, үндэсний ардчилсан өөрчлөлт, эрхзүйн чухал зарчмууд, улс төрийн цоо шинэ тогтолцоог хуульчлан баталгаажуулсан нь Монголын түүхийн асар том үйл явдал болсон өдөр юм
ҮҮПК ийн “Нарны охид” охидын клубээс санаачлан энэхүү өдрөөр багш, ажилтан, ажилчид болон оюутан суралцагчдын дунд Монгол өв соёлоороо бахархан омогших сэтгэлийг бадраах, үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдлэх зорилгоор 11-р сарын 25-ны даваа гаригийг ДЭЭЛТЭЙ МОНГОЛ” өдөр болгон өнгөрүүлээ
Охидын санаачилсан энэхүү үйл ажиллагаанд нийтээрээ дэмжин үндэсний хувцсаараа гоёлоо



Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, сургалтын орчны хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх ногоон эрчим хүчийг сургалтын орчинд ашиглах нөхцлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд Олон улсын Эко-сургууль хөтөлбөрийн анхан шатны сургалтанд БУТ-ийн багш нар болон цахилгааны багш Г.Цогбадрах нийгмийн түншлэлийн ажилтан Ш.Ундрах, нийгмийн ажилтан В.Гэрэлцэцэг нар хамрагдаж захирлын тушаалаар гишүүнтэй Эко зөвлөл түүний дэргэд 7 гишүүн бүхий багш суралцагчдын төлөөлөл оролцсон Эко клуб байгуулагдаж сургуулийн гадаад дотоод орчны үнэлгээг үзүүлэлтээр хийж нэгтгэж цаашид хийх ажлын төлөвлөгөөг гаргаж сургуулийн захиргаанд танилцуулахад бэлэн боллоо



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Барилгын Политехник Коллежийн түүхт 70 жилийн ойг тохиолдуулан мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын багш, судлаачдын дунд зохион байгуулсан Монгол улсын хөгжилд МБСБ-ын гүйцэтгэх үүрэг цаашдын чиг хандлага" сэдэвт ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ-д манай сургуулийн арга зүйч И.Оюунчимэг үсчин мэргэжлийн багш Д.Одгэрэл гоо сайхны үйлчилгээ мэргэжлийн багш Т.Мөнхжаргал нар багаараа амжилттай оролцож Дэд байранд шалгарлаа



МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

СЭТГЭЛИЙН ДЭМ ҮЗҮҮЛЛЭЭ

Үнэт эдлэлийн бүтээгдэхүүн урлал 2а ангийн оюутан суралцагчид 2024 оны 12 сарын 04-ний өдөр сайн үйлсийн аян зохион байгуулж гадаа ажиллаж байгаа хүмүүст болон өөрийн сургуулийн болоод 16-р сургууль, 4 болон 3-р сургуулийн ойр орчимд эцэг эх, асран хамгаалагчийн эргүүл хийж байгаа болон автобус хүлээж буй ахмад настай хүмүүст халуун чацаргана, нэрс болон маск тарааж сэтгэлийн дэм үзүүлээ



SHARE EXPERIENCE AND KNOWLEDGE

Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж нь нийт 84 багштай бөгөөд багш тус бүрийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлсон тоон болон чанарын судалгааны нэгтгэл үр дүнд суурилан SHARE EXPERIENCE AND KNOWLEDGE” буюу олон нийтэд зориулсан нээлттэй хөтөлбөрийг зарлаж байна. Тус хөтөлбөрөөр ҮҮПК-ийн багш, ажилтны болон улсын тэргүүний сайн туршлага, зөвлөмжүүдийг олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр зохион байгвухаа юм.

Тус нээлттэй үйл ажиллагаанд боловсролын байгууллагын нийт багш, ажилчид та бүхнийг өргөнөөр сонирхохыг урьж байна

СПОРТЫН ТЭМЦЭЭН УРАЛДААН

Багш ажилтаны спортын арга хэмжээ нь сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, дартс гэсэн төрлөөр эмэгтэй баг эрэгтэй багуудын дунд явагдсан бөгөөд төрөл тус бүрээр шилдэгүүдээ шалгарууллаа.



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Боловсролын ерөнхий хуулийн дугаар зүйлийн 27.1.2-т Багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийн дагуу Боловсролын ерөнхий газраас Мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багшийг мэргэжлийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтыг Дэлхийн ур чадварын уралдааны агуулга, үнэлгээний стандартыг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах, эксперт багш нарын туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаатай уялдуулан дараах мэргэжлүүдээр зохион байгуулж байна Үүнд: Хоолны үйлчилгээ-Тогооч мэргэжлийн сургалтыг Дэлхийн ур чадварын уралдааны эксперт УУПК-ын багш С.Цэнд-Аюуш нь 12 сарын 9-13 ны хооронд Мэргэжлийн болон политехник коллежийн 37 сургуулийн багш нарыг хамруулж зохион байгуулж байна

